



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 2/126

Дэлгэрхаан сум

Цэнгээнд бүжгийн тэмцээнд дэмжлэг
үзүүлж зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 18 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын 4.3.2.1 заалт болох Иргэдийн оролцоот- Нэг Хэнтий арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд цэнгээнд бүжгийн тэмцээнд оролцох Дэлгэрхаан сумын багт дэмжлэг үзүүлэх зардалд 700,000 (долоон зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Тэмцээний зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Үйл ажиллагааны явцыг зургаар баталгаажуулан тайлан ирүүлэхийг нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн (С.Цэцэгсайхан)-д даалгасугай.

3.Зардалд шаардагдах 700,000 (долоон зуун мянга) төгрөгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Урангоо), нягтлан бодогч (О.Анхцэцэг)-т зөвшөөрсүгэй.

ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН